



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/04

Хэрлэн сум

Мал эмнэлгийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дах заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 2 дугаар заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7.3 “Мал, амьтны халдварт өвчний голомт, шимэгчтэх өвчний гаралт, тархалтыг бууруулж, зарим халдварт өвчний байгалийн халдварлалтыг тогтооно” зорилтын Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд зориулж 793,149,800 (долоон зуун ерэн гурван сая нэг зуун дөчин есөн мянга найман зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Орон нутгийн төсөвт батлагдсан мал эмнэлгийн арга хэмжээний зардлын санхүүжилтийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Э.Үнэнбат)-д, арга хэмжээний үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан) -д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 01-ний өдрийн
А/ОУ дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Төрөл	Нийт
1	Тарилгын үйлчилгээний зардал	498,000,000
2	Вакцины үнэ	287,424,600
3	Дархлаажуулалтын гүйцэтгэл , үр дүнгийн хяналтыг зардал	7,725,200
Дүн		793,149,800



۵۵/۴

۲۵۰۰۰۰ یمن و ۷۵۰۰۰۰ یمن کا حکم ۲۰ یمن

[illegible]